

2.1 Өндөр настны тоо, өсөлт, бүтэц


Монгол Улсын хүн амын өсөлт, хөгжлийн түүхэн хандлагатай уялдаатайгаар өндөр настны тоо, бүтэц өөрчлөгдсөөр ирсэн. Өндөр настны тоо, бүтцийн өөрчлөлт, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг тодруулахын тулд 1940 он, түүнээс өмнөх үеийн хүн амын төрөлт, өсөлтөд нөлөөлсөн зарим онцлог хүчин зүйлстэй холбон үзэх шаардлага урган гарч байгаа юм.

Хүснэгт 2.1 Өндөр настны тоо, жилийн дундаж өсөлт, 1956-2000 он

| Он | Өндөр настны тоо | | | Жилийн дундаж өсөлт, хувиар | |
|------|------------------|-------|--------|-----------------------------|--------------|
| | 60-64 | 65+ | Бүгд | Өндөр настны | Бүх хүн амын |
| 1956 | 32419 | 52743 | 85162 | | |
| 1963 | 35810 | 63988 | 99798 | 2.29 | 2.60 |
| 1969 | 37310 | 71942 | 109252 | 1.52 | 2.76 |
| 1979 | 36659 | 79082 | 115741 | 0.58 | 2.91 |
| 1989 | 36235 | 82628 | 118863 | 0.27 | 2.51 |
| 2000 | 42292 | 82003 | 124295 | 0.41 | 1.40 |

Өндөр настны тоо 1956-1969 оны хоорондох 13 жилд нийтдээ 24.1 мянгаар, буюу 28.3 хувь өсч байсан бол 1969-2000 оны хоорондох 31 жилд 15.0 мян.хүнээр буюу 13.7 хувь өсч, өсөлтийн хэмжээ буурч байгаа нь 1950-иад оныг хүртэл тус улсын хүн амын төрөлт бага, нас баралт ялангуяа нялхсын эндэгдэл өндөр, төдийлэн буурахгүй байсны дээр 1930-аад оны сүүлчээр явагдсан их хэлмэгдүүлэлт, Халх голын дайн зэрэг хүн амын өсөлтөд сөрөг нөлөөлөх хүчин зүйлүүд тохиолдож байсантай холбон үзэж болох юм. Эдгээр хүчин зүйлүүд нь зөвхөн хүн амын төрөлт, өсөлтөд нөлөөлөөд зогсоогүй өнөө үеийн хүн амын нас, хүйсний бүтцэд ч илэрсээр байна.

Зураг 2.1 Хүн амын нас, хүйсний суврага



Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогоор 50, түүнээс дээш настай хүн амын тоо суврагын зөв хэлбэрээс нэлээд цөмөрсөн байгаа нь дээр тайлбарласан хүчин зүйлстэй холбоотой. Харин суврагын оройн хэсэг буюу 80-аас дээш үүний дотор 90-ээс дээш насныхан хэт цөөн зурагт бараг тэмдэглэгдэхгүй, ялангуяа эрэгтэйчүүдийн цөөн байгаа нь Монгол хүний өндөр наслалт, эрүүл мэндийн зэрэгцээ 1930-1940 оны үед залуу буюу идэр настай байсан хүмүүс хэлмэгдэж, дайн байлдаанд оролцсоны улмаас тухайн үед тэдгээрийн тоо цөөн жилүүдийн дотор огцом буурч байсантай холбоотой.

Дээрх хүчин зүйлүүдийн нөлөөгөөр сүүлийн 20 гаруй жилд өндөр настны өсөлтийн хурд буурч, нийт хүн амын жилийн дундаж өсөлттэй зэрэгцүүлэхэд харьцангуй бага байгаа болно (Хүснэгт 2.1)

Өндөр настны сүүлийн 20 илүү жилийн дүр төрх, бүтэц, нийт хүн амд эзлэх хувийн жин, байршил зэргийг нэлээд нарийвчлан хүснэгт 2.2 –д үзүүлэв. Улсын хэмжээний нийт хүн амын тоо 1979-1989 онд 448.9 мянгаар буюу 28.1 хувь өссөн байхад, өндөр настны тоо 3.1 мянгаар буюу 2.7 хувь, 1989-2000 онд нийт хүн амын тоо 329.5 мянга буюу 16.1 хувь өссөн байхад өндөр настны тоо 5.4 мянгаар буюу 4.6 хувь тус тус өссөн байна. Манай хүн амын төрөлт 1950-аад оны сүүлчээс 1970-аад оны сүүлч хүртэл эрчимтэй өсч, 1980-1990 он хүртэл аажим буурч, харин 1990-1995 онд эрчимтэй буурч, сүүлийн жилүүдэд бага түвшинд тогтмолжих хандлагатай болсноос нийт хүн амын өсөлтийн хурд нэлээд саарсан боловч тооллого хоорондын өндөр настны өсөлтөөс өндөр байгаа болно (Хүснэгт 2.1).

Хүснэгт 2.2 Өндөр настны тоо, насны бүлэг, хүйс, байршил, нийт хүн амд эзлэх хувиар, 1979, 1989, 2000 он

| Насны бүлэг | Өндөр настны тоо | | | | | | | | |
|-------------|------------------|---------|--------|---------|---------|--------|---------|---------|--------|
| | 1979 | | | 1989 | | | 2000 | | |
| | эрэгтэй | эмэгтэй | бүгд | эрэгтэй | эмэгтэй | бүгд | эрэгтэй | эмэгтэй | бүгд |
| | Бүгд | | | | | | | | |
| 60-64 | 16779 | 19880 | 36659 | 17598 | 18637 | 36233 | 20778 | 21514 | 42292 |
| 65-69 | 14501 | 18292 | 32793 | 14374 | 17114 | 31488 | 15982 | 19433 | 35415 |
| 70-74 | 10020 | 12799 | 22819 | 9310 | 13166 | 22476 | 8766 | 11473 | 20239 |
| 75-79 | 6278 | 8569 | 14847 | 6228 | 9938 | 16166 | 5832 | 9011 | 14843 |
| 80+ | 3190 | 5433 | 8623 | 4511 | 7987 | 12498 | 3634 | 7872 | 11506 |
| Дүн | 50768 | 64973 | 115741 | 52021 | 66842 | 118863 | 54992 | 69303 | 124295 |
| | Хот | | | | | | | | |
| 60-64 | 7569 | 8253 | 15822 | 8795 | 9753 | 18548 | 10658 | 11231 | 21889 |
| 65-69 | 5829 | 7146 | 12975 | 7233 | 8358 | 15591 | 8145 | 10335 | 18480 |
| 70-74 | 3866 | 5093 | 8959 | 4664 | 6216 | 10880 | 4579 | 6367 | 10946 |
| 75-79 | 2325 | 3321 | 5646 | 2907 | 4360 | 7267 | 3197 | 4766 | 7963 |
| 80+ | 1245 | 2146 | 3391 | 2047 | 3671 | 5718 | 1952 | 4131 | 6083 |
| Дүн | 20834 | 25959 | 46793 | 25646 | 32358 | 58004 | 28531 | 36830 | 65361 |
| | Хөдөө | | | | | | | | |
| 60-64 | 9210 | 11627 | 20837 | 8803 | 8884 | 17687 | 10120 | 10283 | 20403 |
| 65-69 | 8672 | 11146 | 19818 | 7141 | 8756 | 15897 | 7837 | 9098 | 16935 |
| 70-74 | 6154 | 7706 | 13860 | 4646 | 6950 | 11596 | 4187 | 5106 | 9293 |
| 75-79 | 3953 | 5248 | 9201 | 3321 | 5578 | 8899 | 2635 | 4245 | 6880 |
| 80+ | 1945 | 3287 | 5232 | 2464 | 4316 | 6780 | 1682 | 3741 | 5423 |
| Дүн | 29934 | 39014 | 68948 | 26375 | 34484 | 60859 | 26461 | 32473 | 58934 |

Хүснэгт 2.2-ын үргэлжлэл

| Насны бүлэг | Нийт хүн амд эзлэх хувь | | | | | | | | |
|-------------|-------------------------|---------|------|---------|---------|------|---------|---------|------|
| | 1979 | | | 1989 | | | 2000 | | |
| | эрэгтэй | эмэгтэй | бүгд | эрэгтэй | эмэгтэй | бүгд | эрэгтэй | эмэгтэй | бүгд |
| | Бүгд | | | | | | | | |
| 60-64 | 2.1 | 2.5 | 2.3 | 1.7 | 1.8 | 1.8 | 1.8 | 1.8 | 1.8 |
| 65-69 | 1.8 | 2.3 | 2.1 | 1.4 | 1.7 | 1.5 | 1.4 | 1.6 | 1.5 |
| 70-74 | 1.3 | 1.6 | 1.4 | 0.9 | 1.3 | 1.1 | 0.7 | 1.0 | 0.9 |
| 75-79 | 0.8 | 1.1 | 0.9 | 0.6 | 1.0 | 0.8 | 0.5 | 0.8 | 0.6 |
| 80+ | 0.4 | 0.7 | 0.5 | 0.4 | 0.8 | 0.6 | 0.3 | 0.7 | 0.5 |
| Дүн | 6.4 | 8.2 | 7.3 | 5.1 | 6.5 | 5.8 | 4.7 | 5.8 | 5.2 |
| | Хот | | | | | | | | |
| 60-64 | 1.9 | 2.0 | 1.9 | 1.5 | 1.7 | 1.6 | 1.6 | 1.6 | 1.6 |
| 65-69 | 1.4 | 1.7 | 1.6 | 1.2 | 1.4 | 1.3 | 1.2 | 1.5 | 1.4 |
| 70-74 | 1.0 | 1.2 | 1.1 | 0.8 | 1.1 | 0.9 | 0.7 | 0.9 | 0.8 |
| 75-79 | 0.6 | 0.8 | 0.7 | 0.5 | 0.7 | 0.6 | 0.5 | 0.7 | 0.6 |
| 80+ | 0.3 | 0.5 | 0.4 | 0.4 | 0.6 | 0.5 | 0.3 | 0.6 | 0.5 |
| Дүн | 5.1 | 6.3 | 5.7 | 4.4 | 5.5 | 5.0 | 4.3 | 5.4 | 4.9 |
| | Хөдөө | | | | | | | | |
| 60-64 | 2.3 | 3.0 | 2.7 | 2.0 | 2.0 | 2.0 | 1.9 | 2.0 | 2.0 |
| 65-69 | 2.2 | 2.9 | 2.5 | 1.6 | 2.0 | 1.8 | 1.5 | 1.8 | 1.6 |
| 70-74 | 1.6 | 2.0 | 1.8 | 1.1 | 1.6 | 1.3 | 0.8 | 1.0 | 0.9 |
| 75-79 | 1.0 | 1.4 | 1.2 | 0.8 | 1.3 | 1.0 | 0.5 | 0.8 | 0.7 |
| 80+ | 0.5 | 0.9 | 0.7 | 0.6 | 1.0 | 0.8 | 0.3 | 0.7 | 0.5 |
| Дүн | 7.6 | 10.1 | 8.9 | 6.0 | 7.9 | 6.9 | 5.1 | 6.4 | 5.7 |

Өндөр настны тоо, нийт хүн амд эзлэх хувийн жин байршлаар нэлээд ялгаатай байна. Нийт хүн амд өндөр настны эзлэх хувийн жин 2000 онд 1979 оныхоос 2.1, 1989 оныхоос 0.6 пунктээр буурсан байна. Хотод байнга оршин суудаг өндөр настны тоо 1979-1989 онд 11.2 мянгаар буюу 24.0 хувь, 1989-2000 онд 7.4 мянгаар буюу 12.7 хувь өссөн байхад хөдөөд байнга оршин суудаг өндөр настны тоо 1979-1989 онд 8.1 мянгаар буюу 11.7 хувь, 1989-2000 онд 1.9 мянгаар буюу 3.2 хувь тус тус буурсан нь шилжих хөдөлгөөнтэй холбоотой гэж үзэж байна.

Хөдөөгийн нийт хүн амд өндөр настны эзлэх хувь 1979 онд 8.9, 1989 онд 6.9, 2000 онд 5.7 хувийг эзэлж, ерөнхийдөө буурах хандлагатай байгаа боловч энэ үзүүлэлт хотынхоос 1979 онд 3.2, 1989 онд 1.9, 2000 онд 0.8 пунктээр тус тус өндөр байна. Өндөр настны тоо, нийт хүн амд эзлэх хувийн жин аймаг, нийслэлд нэлээд ялгаатай байгааг хавсралт 2.1-2.2-оос үзэж болно.

Нийт хүн амд өндөр настны эзлэх хувийн жин сүүлчийн 3 тооллогоор (1979,1989,2000 он) Дундговьд (11.9, 8.6, 7.2 хувь), Өмнөговь (11.2, 8.6, 7.1хувь), Хэнтий (10.9,7.7, 6.1 хувь) аймгуудад байгаа нь бусад аймаг, нийслэлээс харьцангуй өндөр байна. Энэ нь эдгээр аймгуудад өндөр настны шилжих хөдөлгөөн бусдаас арай бага байдагтай холбоотой байж болох талтай. Харин Орхон (3.9, 3.4, 3.8 хувь), Дархан –Уулд (4.7,3.7, 4.4 хувь) өндөр настны эзлэх хувь бусдаас бага байна. Эдгээр аймгууд харьцангуй сүүлд байгуулагдсан тул эдгээр аймагт шилжин ирэгчдийн дийлэнх нь залуу, идэр насныхан болон хүүхдүүд байсантай холбоотой гэж

үзэж байна. Нийт хүн амд өндөр настны эзлэх хувийн жингээр улсын дунджаас бага байгаа (улсын дундаж 1979 онд 7.3, 1989 онд 5.8 хувь) аймаг, нийслэл 1979,1989 онд тус бүр 7 байсан бол 2000 онд (Улсын дундаж 5.2 хувь) 11 болж өссөн нь шилжих хөдөлгөөнтэй холбон үзэж болох юм. (Аймаг, нийслэлийн нийт хүн амд өндөр настны эзлэх хувийн жинг хавсралт 2.1-ээс үзэж болно).

Хотын хүн амд өндөр настны эзлэх хувийн жин улсын дунджаас 13 аймагт өндөр (Хавсралт 2.2) байгаагийн дотор Хөвсгөл, Дундговь, Өмнөговь, Булган, Говьсүмбэр аймгуудад нэлээд өндөр байна. Хөдөөгийн хүн амын дотор өндөр настны эзлэх хувийн жин Өмнөговь, Дундговь, Хэнтий, Төв, Дорноговь, Булган аймгуудад өндөр байна. Говийн бүсийн аймгуудын нийт хүн амд өндөр настны эзлэх хувийн жин хот, хөдөөд өндөр байгааг эдгээр аймгийн төр, захиргааны байгууллагууд анхаарч, тэдэнд тавих анхаарал халамж, нийгмийн үйлчилгээг нэмэгдүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй байна.

Монгол Улсын өндөр настны тоо, нийт хүн амд эзлэх хувийн жин 1990-2000 оны хооронд хамгийн бага түвшинд байсан ба цаашид нэлээд нэмэгдэх магадлалтай юм. Энэ нь 1950-иад оны үеэс тус улсын хүн амын төрөлт нэмэгдэж эхэлсэн төдийгүй эдийн засаг, нийгмийн хөгжил хурдасч эрүүл мэндийн бүх төрлийн үйчилгээ үнэ төлбөргүй байсантай холбоотой юм.. Мөн 1950-аад оны сүүлчээр хүн амыг эрүүлжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээнүүд, үүний дотор арьс өнгө, сүрьеэ өвчинтэй хүмүүсийг илрүүлэн, үнэ төлбөргүй эмчлэн эдгэрүүлэх арга хэмжээ авсан билээ. Манай орны эрүүлийг хамгаалах систем тууштай хөгжихийн хирээр хүн амын нас баралт, ялангуяа хүүхдийн болон нялхсын нас баралт нэлээд буурсан нь төрөлт нэмэгдэж, хүн амын өсөлтийн хурд өндөр байсан үед төрсөн хүмүүс 2015-2020 оны үед өндөр насанд шилжих тул тэр үеийн өндөр настны тоо өмнөх үеийнхээсээ эрс өсөх болно. Нөгөө талаас хүн амын өсөлтийн хурд сүүлийн үед нэлээд буурч байгаа ба цаашид 1960-1970-аад оны түвшинд хүрч нэмэгдэх магадлал байхгүй тул өндөр настны нийт хүн амд эзлэх хувийн жин буурахгүй юм.

Хүснэгт 2.3. Өндөр настны тоо, нийт хүн амд эзлэх хувь,
 2005-2025 он (Хэтийн тооцооны дунд хувилбараар)

| | 2005 | | | 2010 | | | 2015 | | |
|-------------------------|---------|---------|--------|---------|---------|--------|---------|---------|--------|
| | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд |
| Өндөр настны тоо | 65494 | 78910 | 144404 | 72400 | 87528 | 159928 | 86914 | 104380 | 191294 |
| Нийт хүн амд эзлэх хувь | 5.2 | 6.1 | 5.7 | 5.4 | 6.4 | 5.9 | 6.1 | 7.2 | 6.6 |

Хүснэгт 2.3-ын үргэлжлэл


| | 2020 | | | 2025 | | | | | |
|-------------------------|---------|---------|------|---------|---------|--------|--------|--------|--------|
| | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | | | |
| Өндөр настны тоо | | | | 116089 | 138341 | 254430 | 158846 | 188490 | 347336 |
| Нийт хүн амд эзлэх хувь | | | | 77.1 | 9.0 | 8.4 | 10.1 | 11.8 | 11.0 |

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын дүнг үндэслэн хийсэн тус улсын хүн амын 2000-2025 оны хэтийн тооцооны дунд хувилбараас үзэхэд өндөр настны тоо 2005 онд 2000 оныхоос 16.2 хувь буюу 20.1 мянган хүнээр, 2010 онд 2000 оныхоос 28.7 хувь буюу 35.6 мянган хүнээр өсөхөөр байгаа нь өнөөгийн 10-аад сумын нийт хүн амтай тэнцэх хэмжээний хүнээр нэмэгдэх тооцоо гарч байна. Өндөр настны тоо 2010 онд 2005 оныхоос 10.7 хувиар буюу 15.5 мянган хүнээр нэмэгдэхээр урьдчилан төсөөлөгдөж байна.

Нийт хүн амд өндөр настны эзлэх хувийн жин 2020 гэхэд 8.4 хувь, 2025 онд 11.0 хувь болохоор байгаа нь анхаарал татаж байна. Нийт хүн амд өндөр настны эзлэх хувийн жин 10 хувиас давсан тохиолдолд тухайн улс орны хүн ам хөгширч байгаа гэж үздэг. Хэтийн тооцооны дунд хувилбараас үзэхэд 2020 оноос хойш тус улсын хүн ам насны бүтцээр “хөгшрөх” төлөвтэй байгааг төр, засгаас анхаарч хүн амын төрөлт, өсөлтийн хурдыг нэмэгдүүлэх талаар тодорхой бодлого боловсруулж, хэрэгжүүлэхийг сануулж байгаа хэрэг юм.

Хүн амын төрөлт, өсөлтийн үе үеийн онцлогоос хамаарч хүн амын насны бүтцэд нэлээд өөрчлөлт гарч байсныг дараах зургаас харж болно

Зураг 2.2 Нийт хүн амд 0-14, 60, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувийн жин



Олон улсын нийтлэг жишгийг харгалзан өндөр настныг 60-64, 65-74, 75, түүнээс дээш гэж ангилж, насных нь бүтцийг тодорхойлов.

60-64 насныхан бол өндөр настны дотроо тэтгэвэр тогтоолгон авах эрх үүсээд удаагүй, “Төрийн албаны тухай” Монгол Улсын хуулийн дагуу төрийн албан хаагч нь 65 нас хүртэл ажиллах боломжтой зэргийг үндэслэж өндөр настан дотроо харьцангуй “залуу” гэж үзэж байгаа болно. 65-74 насанд өндөр настангууд өөрийн ажлын дадлага туршлага зэргийг үндэслэн ажиллах, ялангуяа хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд оролцох боломжтой, өндөр настангууд дотроо “дунд” насныхан гэж үзэж байгаа

болно. Харин 75 түүнээс дээш насныханыг манай орны нөхцөлд ажиллах чадвар нь эрс буурсан, асаргаа сувилгаа, нийгмийн халамжийн үйчилгээг өмнөх 2 насны бүлгийнхэнээс илүү их шаарддаг зэргийг үндэслэн өндөр настангуудын “ахимаг” үеийнхэн гэж ангилж байгаа болно.

Хүснэгт 2.4 Өндөр настны байршил, насны бүтэц, хувиар

| | Бүгд | Үүнээс: насны бүлгээр | | |
|-------|-------|-----------------------|-------|------|
| | | 60-64 | 65-74 | 75+ |
| Бүгд | 100.0 | 34.0 | 44.8 | 21.2 |
| Хот | 100.0 | 33.5 | 45.0 | 21.5 |
| Хөдөө | 100.0 | 34.6 | 44.5 | 20.9 |

Өндөр настны насны бүтэц байршил, аймаг, нийслэлээр харилцан адилгүй байна (Хавсралт 2.3-2.8). Хотын өндөр настны дотор 75, түүнээс дээш насныханы эзлэх хувийн жин Дундговь, Өмнөговь, Хэнтий, Завхан аймагт, хөдөөгийн өндөр настны дотор 75, түүнээс дээш насныхан Дундговь, Өмнөговь, Хэнтий, Дорноговь аймагт бусдаас өндөр байна. Нийт хүн амд өндөр настны эзлэх хувийн жин, өндөр настнуудын дотор 75, түүнээс дээших насныханы эзлэх хувийн жингээр говийн бүсийн болон Хэнтий зэрэг аймгууд нэлээд өндөр хувийг эзэлж байна.

Хүн амын тоо, бүтэц байршилд нөлөөлдөг үндсэн үзүүлэлтүүдийн нэг нь шилжин суурьшилт, шилжих хөдөлгөөн юм. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогод хүн амын шилжих хөдөлгөөны асуултыг шинээр оруулсан юм.

Төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд оролцоогүй уугуул аймаг, нийслэлдээ сууж байгаа 60, түүнээс дээш настай 69975 хүнийг хүснэгт 2.5-д үзүүлэв. Харин хавсралт 2.9 –д байгаа 76186 хүний дотор тооллогын үед төрсөн аймаг, нийслэлдээ сууж байгаа боловч амьдралынхаа туршид төрсөн аймаг, нийслэлээсээ гадагш шилжих хөдөлгөөнд оролцоод буцаж ирсэн 6211 хүн орсон үзүүлэлт юм.

Хүснэгт 2.5 Өндөр настны шилжин суурьшилт

| | Бүгд | | Хот | | Хөдөө | |
|---|--------|-----------------|--------|-----------------|--------|-----------------|
| | хүн ам | дүнд эзлэх хувь | хүн ам | дүнд эзлэх хувь | хүн ам | дүнд эзлэх хувь |
| 60, түүнээс дээш настай хүн ам-бүгд | 124295 | 100.0 | 65361 | 100.0 | 58934 | 100.0 |
| а. Төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд оролцоогүй | 69975 | 56.3 | 22263 | 34.1 | 47712 | 81.0 |
| б. Шилжиж ирсэн | 54320 | 43.7 | 43098 | 65.9 | 11222 | 19.0 |
| Үүнээс: | | | | | | |
| 1 жил хүртэл | 2662 | 2.1 | 2162 | 3.3 | 500 | 0.8 |
| 1-4 жил | 4301 | 3.5 | 3308 | 5.1 | 993 | 1.7 |
| 5-9 жил | 3545 | 2.9 | 2663 | 4.1 | 882 | 1.5 |
| 10 + жил | 43812 | 35.2 | 34965 | 53.5 | 8847 | 15.0 |

Хотод байнга оршин суудаг өндөр настангуудын дийлэнх нь шилжин ирсэн байхад хөдөөгийн өндөр настангуудын 81.0 хувь нь уугуул нутагтаа амьдарч байна. Энэ нь хөдөөнөөс хотруу шилжин суурьшигчдын дийлэнх нь залуу, идэр насныхан байж, хөдөөд гол төлөв хөгшчүүд төрсөн газартаа үлдэж байгааг харуулж байна. Өндөр настны шилжих хөдөлгөөний талаарх аймаг, нийслэлээр гаргасан дэлгэрэнгүй үзүүлэлтийг хавсралт 2.9а, 2.9б, 2.9в-гээс үзнэ үү

Хүснэгт 2.6 Шилжин суурьшсан өндөр настан, байршил, насны бүлэг, хувиар

| Хүн амын байршил | Бүгд | Үүнээс: насны бүлгээр: | | | | |
|------------------|-------|------------------------|-------|-------|-------|-----|
| | | 60-64 | 65-69 | 70-74 | 75-79 | 80+ |
| Бүгд | 100.0 | 35.2 | 28.3 | 16.4 | 11.6 | 8.4 |
| Хот | 100.0 | 34.0 | 28.4 | 16.8 | 11.8 | 8.9 |
| Хөдөө | 100.0 | 39.9 | 27.9 | 14.8 | 10.9 | 6.4 |

2.2 Өндөр настны хүйсийн харьцаа, насжилтын индекс, голч нас

Судалгааны энэ хэсэгт өндөр настангуудын хүн ам зүйн гол үзүүлэлтийн өөрчлөлтүүдийг тусгах болно.

Өндөр настангуудын хүйсийн харьцаа. Хүйсийн харьцааг 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоогоор илэрхийлдэг.

Өндөр настны голч нас. Энэ үзүүлэлтээр өндөр настны тоо ямар наснаас хоёр тэнцүү хэсэгт хуваагдаж байгаа буюу насжилт нэмэгдэж байгаа эсэхийг харуулна.


Насжилтын индекс. Энэ үзүүлэлтээр 15 хүртэл настай 100 хүүхдээс дунджаар хэд нь 60, түүнээс илүү наслах боломжтойг илэрхийлдэг.

Хүснэгт 2.7 Өндөр настны хүн ам зүйн үндсэн зарим үзүүлэлтүүд, 1979, 1989, 2000 он

| | 1979 | 1989 | 2000 |
|------------------------------|-------|-------|-------|
| Хүйсийн харьцаа | 78 | 78 | 79 |
| Бүх хүн амд эзлэх хувийн жин | 7.3 | 5.8 | 5.2 |
| Голч нас | 63.23 | 63.68 | 62.80 |
| Насжилтын индекс | 16.4 | 13.9 | 14.6 |
| Жилийн дундаж өсөлт | 0.58 | 0.27 | 0.41 |

Монгол Улсын хүн амын хүйсийн харьцаа 1979 онд 100.4, 1989 онд 99.7, 2000 онд 98.5 болж буурах хандлагатай байгаа болно. Өндөр настны хувьд хүйсийн харьцаа улсын дунджаас нэлээд доогуур байдаг нь эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс ямагт өндөр байдагтай холбон тайлбарлаж болох юм. Нас ахих тутам хүйсийн харьцаа буурдгийг дараах зургаас харж болно.

Зураг 2.3 Өндөр настны хүйсийн харьцаа, насны бүлгээр, 2000 он



Өндөр настны голч нас 2000 онд 1989 оноос бага зэрэг буурч байгаа нь шинээр өндөр насанд шилжиж байгаа хүний тоо өмнөх 10 жилийнхээс бага зэрэг нэмэгдсэнтэй холбоотой юм. 1979-1989 онд 60-64 настай хүний тоо 424 хүнээр буурч байсан бол 1989-2000 онд энэ үзүүлэлт 6057 хүнээр нэмэгдсэн байна (хүснэгт 2.1). Харин насжилтын индекс 2000 онд 1989 оныхоос 0.7 пунктээр нэмэгдэж, 0-14 настай зуун хүүхдээс 15 нь 60, түүнээс дээш наслахаар байна.

2.3 Хүн ам зүйн ачаалал, түүний чиг хандлага

Хүн амын насны бүтцийн өөрчлөлтийг илэрхийлэх нэг гол үзүүлэлт нь хүн ам зүйн ачаалал юм. Хүн ам зүйн ачаалал нь хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгч хүний харьцааг тодорхойлдог. Хөдөлмөрийн насны (15-59 насны) буюу тэжээгч, тэжээлгэгчийн (0-14 настай хүүхэд, 60, түүнээс дээш насныхан) харьцааг тодорхойлж байгаагаараа энэ үзүүлэлт эдийн засгийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйлийн нөлөөг илэрхийлдэг ач холбогдолтой юм.

Хүснэгт 2.8 Хүн ам зүйн ачаалал, 1979, 1989, 2000 он

| Хүн ам зүйн ачаалал | 1979 | 1989 | 2000 |
|---------------------|------|------|------|
| 0-14 насаар тооцсон | 91.3 | 80.0 | 60.6 |
| 60+ насаар тооцсон | 15.0 | 11.1 | 8.9 |

Хүн ам зүйн ачаалал 2000 онд 1979 оныхоос 36.8, 1989 оныхоос 21.6 пунктээр буурсан нь хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгчийн тоо сүүлийн 20 гаруй жилд гуравны нэгээс илүүгээр буурсныг харуулав. Сүүлийн 11 жилд тэжээлгэгчийн тоо 22 хүнээр буурсны дотор хүүхдийн ачаалал 19-өөр, хөгшдийнх 2-оор буурчээ. Сүүлийн жилүүдэд төрөлт багасч байгаатай уялдан хүн ам зүйн ачааллын доторх хүүхдийн ачаалал буурч, харин хөгшчүүдийнх ойролцоо түвшинд хадгалагдах төлөвтэй байна. Хүн ам зүйн ачаалал 2005 онд 56.2, үүний дотор хүүхдийнх 47.4, хөгшчүүдийнх 8.8, 2010 онд нийт ачаалал 48.8 үүний дотор хүүхдийнх 40.0, хөгшчүүдийнх 8.8 байх төлөвтэй байна.

